

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2022 ОНД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**  
(Сайхан-Овоо суманд хамааралтай заалт)

2022.12.19

Онги

№	Захирамжийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
3	A/298	Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар удирдамж, чиглэл батлах тухай	3	2. Удирдамж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар, удирдамж, чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагийн дарга	Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэндийн удирдамж, чиглэлийн дагуу 2022 онд сумын хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2022 оны 07 сарын 07-ны өдрөөр сумын Засаг даргаар батлуулж төсвийн байгууллагуудад хамтран ажиллах үүрэг чиглэл өгөн, дээрх арга хэмжээг 2 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавин үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 77.6%-тай бөгөөд төсөв, цаг хугацааны нөхцөл байдлаас 2 арга хэмжээ огт хэрэгжээгүй болно.	100%
4	A/299	“Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжье” аян зохион байгуулах тухай 2022.07.01	4	1. Аяныг сум, байгууллагын хэмжээнд өрнүүлэн, сар бүр аяны явцыг дүгнэж, 9 дугаар сарын 1-нд явцын тайланг, 12 дугаар сарын 01-нд нэгдсэн тайланг ажлын хэсэгт ирүүлэхийг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.	Сум, байгууллагын дарга нарт	“Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжье” аяныг сумын болон байгууллагын хэмжээнд 2022 оны 07 сарын 11-нээс 12 сарын 11-ний хооронд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөж бусад байгууллага, иргэдийг уриалах болон соён гэгээрүүлэх ажлыг 100% зохион байгуулан ажилласан. Аяны хүрээнд олон нийт, өсвөр насны хүүхдүүд болон төрийн албан хаагчдад сургалт сурталчилгаа, хэлэлцүүлгийг танхимаар болон цахимаар ттүгээж, албан байгууллагууд зөв хандлагыг түгээх аянд хамт олноороо оролцож, хамгийн зөв хандлагатай нэг албан хаагчийг шалгаруулж алдаршуулах ажлыг зохион байгуулж идэвхтэй оролцсон.	100%

						Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо-100, хэлэлцүүлэгт 67 иргэн, цахимаар сурталчилгаа мэдээ мэдээллийг 3 удаагийн давтамжтай түгээж хандалтын тоо 1263.	

7	A/337	Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурин газрын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай 2022.08.17	8	2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 20-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны дотор хангаж, тайланг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс. Албадын дарга нарт үүрэг болгосугай.	ХБТХОХ  сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс	<p>Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсгийг 2022 оны 08 сарын 31-ний өдрийн сумын Засаг даргын А/65 дугаар захирамжаар байгуулж, өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангуулахаар 15 арга хэмжээ төлөлөн ажиллаж, хэрэгжилтийг 100% ханган ажилласан байна.</p> <p>Сумын аюулгүй нөөцөд 36 тн өвс, 15тн тэжээл нөөцлөөд байна. Албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд төвийн халаалтын шугаманд холбогдон хаалга цонхны дулаалгыг бүрэн хийсэн. Бэлтгэсэн нүүрсний хэмжээ 120тн байна.</p> <p>Малчидтай 2021 онд хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 2022 оны 11 сард дүгнэн, гэрээг сунгах ажлыг хийсэн. Өвс тэжээлийн бэлтгэл ажил 100%, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга эмчилгээнд 100%, угаалга вандалтанд 34% нь хамрагдсан байна.</p>	100%
17	A/423	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг	18	2.Тус аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Гурвансайхан сумын	ХБТХОХ МХГ Гурвансайхан сум Өлзийт сум Өндөршил сум	Хамааралгүй	-

		сунгах тухай 2022.11.01		Засаг дарга (Э.Адьяабаатар), Өлзийт сумын Засаг дарга (Б.Гасрандорж), Өндөршил сумын Засаг дарга (У.Алтанхүү), Луус сумын Засаг дарга (Б.Өлзийхишиг) нарт тус тус үүрэг болгосугай.	Луус сум		
24	A/455	Архи, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх олгох тухай  2022.11.25	26	2. Гарсан шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Сайнцагаан сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХБТХОХ ЦГ МХГ ТХ  Сайнцагаан сум	Хамааралгүй	-
26	A/461	Спиртийн сул агууламжтай ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх түр зөвшөөрөл олгох тухай 2022.11.30	28	3. Гарсан шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат),	ХБТХОХ ЦГ МХГ Сайнцагаан сум	Хамааралгүй	-

				Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.			
29	A/471	Мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай 2022.12.07	31	2. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд нэгэн зэрэг явуулж, мал, тэжээвэр амьтдыг нүд үзэж нэг бүрчлэн тоолох ажлыг Үндэсний Статистикийн хорооноос баталсан заавар, удирдамжийн дагуу зохион байгуулахыг комиссын нарийн бичгийн дарга (Б.Энхтуяа)-д, мал тооллогыг хугацаанд нь хариуцлагатай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	СХ сумдын Засаг дарга нарт	2022 оны 12 сарын 05-ны өдрийн сумын Засаг даргын А/98 дугаар захирамжаар Мал тооллогын комиссыг 22 хүний бүрэлдэхүүнтэй, сумын хяналтын тооллогын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2022 оны 12 сарын 07-ноос 17-ны өдрийг дуустал Онги, Мааньт, Найз, Төгрөг багийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтдын тооллогыг явуулж дууссан. Суманд мэдээлэл шивэх ажил 12 сарын 19-ны өдрөөр дуусч, урьдчилсан байдлаар 178749 тоо толгой мал тоологдсон байна.	100%
<b>100 хувь-4, 70 хувь-, 30 хувь-, 0 хувь-, ХБ-</b>							

Хэрэгжилт тооцсон: ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн

Э.Отгонцэцэг

Хянасан: ЗДТГ-ын дарга

С.Болоржаргал